



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2024 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/58

Улаанбаатар хот

Дотоод аудит зохион байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоол, Төвийн “Дотоод аудит зохион байгуулах” журмыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Менежментийн тогтолцооны ISO 9001:2015, ISO 45001:2018 болон Лабораторийн чанар ба чадавхад тавигдах шаардлага ISO 15189:2015 стандартын хэрэгжилтэд дотоод аудит хийх бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, Дотоод аудит хийх төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Стандартын хэрэгжилтэд дотоод аудит хийх нөхцөлийг бүрдүүлэн, хамтран ажиллахыг алба, тасгийн дарга, эрхлэгч нарт, дотоод аудитын үнэлгээний дүн, тайланг төвийн Удирдлагын зөвлөлд танилцуулан зохих арга хэмжээ авч ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Э.Тунгалагтуяа)-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, маркетингийн албаны дарга (Ч.Батболд)-д үүрэг болгосугай.


ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР

1308010374


ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2024 оны 09 дүгээр сарын 23-ны
өдрийн А/58 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт



Дотоод аудит хийх багийн бүрэлдэхүүн

Ахлагч:	Э.Тунгалагтуяа	Цусны чанар, аюулгүй байдлын албаны дарга
Гишүүд:	Т.Алимаа	Цусны чанар, аюулгүй байдлын албаны Дотоод аудитор
	Э.Чагцалдулам	Халдвар судлаач эмч, ХЭМАБ хариуцсан ажилтан

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2024 оны 09 дүгээр сарын 25-ны
өдрийн А/38 дугаар тушаалын
2 дугаар хавсралт



Дотоод аудит хийх төлөвлөгөө

№	Үйл ажиллагаа	Хугацаа /Сар, өдөр/	Хариуцах эзэн	Хүрэх үр дүн
1.	Аудит хийх мэдээллийг хүргүүлнэ	2024.08.23	Э.Тунгалагтуяа Э.Чагцалдулам	Аудит хийх мэдээллийг ажиллагсад хүлээн авч, бэлэн байдлыг хангасан байна.
2.	Аудитын багийн ахлагч, гишүүдийг сонгож үндэсний төвийн захирлын тушаал гаргах	2024.09.25	Э.Тунгалагтуяа	Аудит хийх багийг томилсон захирлын тушаал гарсан байна.
3.	Аудитын багийн ахлагч, гишүүдэд аудит явуулах чиглэл өгөх	2024.09.25	Э.Тунгалагтуяа	Аудитын үйл ажиллагаа журмын дагуу зохион байгуулагдсан байна.
4.	Аудитыг зохион байгуулах	2024.09.26- 2024.09.30	Багийн гишүүд	
5.	Аудитын тайлан бичих	2024.09.30	Багийн гишүүд	Аудитын тайлан, зөвлөмж гарч, аудитад хамрагдсан ажиллагсдад танилцуулагдсан байна.
6.	Хаалтын хурал	2024.09.30	Багийн гишүүд	
7.	Үл тохирол хаах, сайжруулах санал зөвлөмжийн хэрэгжилтийг хангах	2024.11.01	Холбогдох алба, тасаг	Гарсан үл тохирлыг арилгаж, сайжруулах санал зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.